



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 04 өдөр

Дугаар В/02

Хэрлэн сум

Журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Захиргааны ерөнхий хуулийн 45.1 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний 202 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Аймгийн сайн малчин шалгаруулах журам"-д дараах өөрчлөлтүүдийг оруулсугай. Үүнд:

- "Аймгийн сайн малчин" гэснийг "Аймгийн аварга малчин" гэж
- Журмын 1 дүгээр зүйлийн 3-д "Сум бүрээс 2 малчин нийт 41" гэснийг "Сум тус бүрээс 2 хүртэлх малчин, тосгон бүрээс 1 малчин" гэж
- Журмын 4 дүгээр зүйлийн 1-д "200.0 мянган төгрөг" гэснийг "100.0 мянган төгрөг" гэж
- Мөн тус зүйлд Энгэрийн тэмдгийг гэр бүлийн гишүүн /эхнэр/-т цуг олгоно гэж тус тус өөрчилсүгэй.

Хоёр. "Аймгийн аварга малчин шалгаруулах журам"-ын дагуу шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгаж байхыг Санхүү төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т даалгасугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 он 12 дугаар сарын 30-ны А/602 дугаар захирамжийн 1 дүгээр зүйлийн 3, 4 дүгээр зүйлийн 1 дэх заалтуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

"АЙМГИЙН АВАРГА МАЛЧИН" ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгох, мал сүргийнхээ тоо толгойг зохистой хэмжээнд өсгөх, малын ашиг шим, үүлдэр угсааг сайжруулах, бүтээгдэхүүний гарц чанарыг нэмэгдүүлэх болон нийгэмд оруулж буй хувь нэмрийг нь үнэлж урамшуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан Хэнтий аймгийн харъяат, тухайн суманд тогтвор суурьшилтай амьдарч байгаа 18 сум, 5 тосгоны малчдыг сүүлийн 2 жилийн ажлын үзүүлэлтийг үндэслэн "Аймгийн аварга малчин"-аар шалгаруулна.

1.3. Сум тус бүрээс 2 хүртэлх малчин, тосгон тус бүрээс 1 малчны материалыг ирүүлнэ.

1.4. "Аймгийн аварга малчин"-аар шалгаруулах ажлыг аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

Хоёр. Шагналд тодорхойлох үндэслэл

2.1. "Аймгийн аварга малчин"-аар тодорхойлогдож байгаа малчин дараах нийтлэг шаардлагыг хангасан байна.

2.1.1. Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээ эрхэлдэг нэгжтэй байнгын гэрээтэй ажиллаж урьдчилан сэргийлэх арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулсан, өрхийн дэвтэр хөтөлсөн, эрүүл сүрэгтэй болсон байна.

2.1.2. Мал сүргээ үзлэг ангилалтанд хамруулсан, мал бүр нь дугаар, им тамгатай, үржилд ашиглаж буй малын анги, ашиг шимийн гарц чанар нь мэргэжлийн байгууллагаар тогтоогдсон байна.

2.1.3. Мал сүргээ жил бүр малын эрсдэлийн даатгалд хамруулсан байна.

2.1.4. Аймаг, сум орон нутагтаа тодорхой 2-оос доошгүй ажлыг хийж, нийгмийн хариуцлагаа биелүүлж, дэмжлэг үзүүлэх зэргээр тодорхой хувь нэмэр оруулсан байх

2.1.5. Малгүй өрхийг малжуулах, малчны бүлэг хоршоо байгуулах, малаа гэрээ түрээсээр маллуулах, өрхийн үйлдвэрлэл эрхлэх зэргээр шинээр ажлын байр бий болгон өрхийн орлогыг нэмэгдүүлж, хөдөөд ядуурлыг бууруулахад тодорхой хувь нэмэр оруулсан байх

2.1.6. Уламжлалт мал маллагааны арга туршлагыг малчдад эзэмшүүлэх талаар санаачлага гарган ажиллаж шавь малчинтай болсон байх.

2.1.7. Малчин өөрөө болон гэр бүлийн гишүүд нийгмийн даатгалын сайн дурын даатгал болон эрүүл мэндийн даатгалд жил бүр хамрагдсан байх.

2.1.8. Холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар хураамжийг жил бүр төлсөн байх.

2.1.9. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үүргээ хэрэгжүүлж ажилласан байх. /Малаа им тамга бусад таних тэмдэгтэй болгох, зүсмийн бүртгэл хөтөлж, бод малаа зурагжуулсан байх, малаа байнгын хариулга маллагаатай байлгах талаар арга хэмжээ авч орчин үеийн ололт амжилтыг ашигласан байх/

2.1.10. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар орон нутгийн болон улирлын онцлогт тохируулан арга хэмжээ авсан байх. /ХХАА-н сайд, Хууль зүйн сайдын 2016 оны А/160, А/73 тоот хамтарсан тушаалыг биелүүлж малчдын бүлэг холбоо байгуулж ажилласан байх/

2.2. "Аймгийн аварга малчин"-аар тодорхойлогдож буй малчин нь дор дурьдсан шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна.

2.2.1. Бодод шилжүүлснээр тал хээрийн бүсэд 250-иас доошгүй, ойт хээрийн бүсэд 100-гаас доошгүй толгой малтай, мал сүргийн тоо толгойг сүүлийн 2 жил дараалан тогтвортой өсгөсөн байх.

2.2.2. Сүрэгт эзлэх хээлтэгчийн хувийн жин бог малд 48, бод малд 30-аас доошгүй хувьд хүргэж, үржлийн албаар баталгаажсан жишигт тэнцсэн хээлтүүлэгчтэй болж малын чанарыг сайжруулсан байх.

2.2.3. Оны эхний 100 хээлтэгч мал тутмаас бойжуулсан төлийн тоо жил дараалан төрөл бүр дээр өссөн байхаас гадна хээлтэгч тутмаас төл бойжуулсан байх.

2.2.4. Хонин толгойд шилжүүлсэн нэг мал тутамд хангайн бүсэд 30 кг, тал хээрийн бүсэд 10 кг өвстэй тэнцэхүйц хэмжээний хадлан тэжээл бэлтгэсэн байх.

2.2.5. Тухайн нутагт сүүлийн 5 жил тогтвор суурьшилтай амьдарсан, бэлчээр нутгийн маргаангүй, малын тоо нь бэлчээрийн даац багтаамжаас хэтрээгүй, бэлчээрийг талхлагдлаас хамгаалах ямар нэгэн арга хэмжээ авсан байх

2.2.6. Өөрийн өмчлөл, эзэмшлийн өвөлжөө, хаваржааны газартай, худаг, уст цэгтэй, түүнийгээ засаж тохижуулсан байх.

2.2.7 Үржлийн мал бойжуулж, борлуулсан, цөм сүрэг болон шилмэл малын сүрэгт эзлэх хувийн жин нийт малын 10 хувьд хүрсэн байна.

2.2.8. Нийт сүрэгт эзлэх ямааны тоо 25 хувиас ихгүй байна.

Гурав. Тодорхойлолт бүрдүүлэх, шалгаруулах зарчим

3.1. Тодорхойлогдож буй малчин доорх шаардлагыг хангасан байна.

3.1.1. Сумын сайн, аварга малчин болсноос хойш хоёроос доошгүй жил тогтвортой амжилт гаргаж, энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангасан малчныг "Аймгийн аварга малчин"-аар шагнуулахаар тодорхойлно.

3.1.2. "Аймгийн аварга малчин"-аар тодорхойлох малчдын материалыг багийн Иргэдийн Нийтийн Хурал, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн 2 хүртэлх малчныг шалгаруулан тодорхойлно.

3.1.3. Тодорхойлолт болон материалын бүрдлийг сумын Засаг даргын тамгын газар хянаж, шаардлагатай бол газар дээр нь шалгаж, баталгаажуулан жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газарт ирүүлнэ.

3.2. "Аймгийн аварга малчин"-аар шалгаруулахаар тодорхойлохдоо дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна.

3.2.1. Малчны товч анкет /журмын 1 дүгээр хавсралт/

3.2.2. Ажлын үзүүлэлт /журмын 2 дугаар хавсралт/

3.2.3. Багийн Иргэдийн нийтийн хурлын тэмдэглэл

3.2.4. Сумын ИТХТэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэл

3.2.5. Сум, багийн Засаг даргын тодорхойлолт

3.2.6. Холбогдох байгууллагаас гаргасан баталгаа, тодорхойлолт /журмын 3 дугаар хавсралт/

3.3. Малын тоо, бүтээгдэхүүний дүнд худалдан авсан болон тавиул малын тоог оруулж тооцохгүй.

Дөрөв. Шагнал олгох

4.1. "Аймгийн аварга малчин"-аар шалгарсан малчин тус бүрийг "Аймгийн аварга малчин"-ны үнэмлэх, энгэрийн тэмдэг, дурсгалын зүйл, 100,0 мянга /Нэг зуун мянга/-н төгрөгөөр шагнана. /Энгэрийн тэмдэгийг гэр бүлийн гишүүн /эхнэр/-т цуг олгоно/.

4.2. Шагналыг жил бүрийн "Хаврын тэргүүн сарын шинийн нэгэн"-ээс өмнө гардуулна.